



АРДЧИЛЛЫГ БАТАТГАХЫН ТӨЛӨӨХ  
ҮЙЛСТ ХАНДИВ ӨРГӨХИЙГ УРИАЛЛАА

III нүүрт

ОНИЦЛОХ ХУУДАС

ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨСӨЛТӨД БИД  
БҮГДЭЭРЭЭ БУРУУТАЙ

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр -12  
Шөнө -17

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## Итгэл дагуулах

Н.БАТЗАЯА

Хотын зүүн хэсэгт байрлах Хотаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн ойролцоо тун удахгүй нэгэн том цогцолбор барилга сүндэрлэнэ. Манай улсын боловсрол болон эрүүл мэндийн салбарт хийгдэж буй томоохон бүтээн байгуулалтын нэг болох уг барилгын ажлын гүйцэтгэлийг хүн бүхэн сэтгэл догдлон хүлээж байгаа гэхэд хэтийдсэн болохгүй. Учир нь тэр барилга бол Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар барьж буй АШУУИС-ийн Сургалтын эмнэлгийн шинэ байр юм.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын 60 мөр

Махаа импортлох бус экспортлооч

Б.ДАВАА

Японы Мияконожо хотын Хөдөө аж ахуйн хэлтсийн дарга Иши Ёшихиро нарын төлөөлөгчид саяхан манай нийслэлд саатаж, Засаг даргын орлогч Ж.Батбаясгалантай уулзалт хийхдээ Монгол руу мах экспортлох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн гэдэг. Гэхдээ зөвхөн энэ удаа л импортын махны асуудал яригдсан гэвэл өрөөсгөл. Үүндээ хүн амьн ихэнх нь малын махыг хүнсэндээ хэрэглэдэг Монголын зах зээлийг аль эртнээс л тэд сонирхсон байдаг. Өнгөрсөн онд ч гэсэн Мияконожо хотын орлогч дарга нийслэлд айлчлахдаа энэ талаар дурьдаж, түүгээр барахгүй Элчин сайдын яамаараа дамжуулан брэнд махаа танилцуулах өдөрлөг үйл ажиллагааг зохион байгуулж байсан юм.

Төгсгөл нь III нүүрт

## АШУУИС-ИЙН СУРГАЛТЫН ЭМНЭЛЭГ



### ЗАЛУУСЫН ХОТХОН X Apartment ЯПОН ЧАНАР

Та бүхэндээ 100% ашиглалтанд ороон, Япон архитекторын орон зайн төгс зохион байгуулалт бүхий Залуусын хотхон "X Apartment"-ыг танилцуулж байна. Хотын А зэрэглэлийн бүсэд байрлах Залуусын хотхон "X Apartment" нь оршин суугчдын тав тухыг дээд зэргээр хангахаар төлөвлөгдсөн хамгийн бодит үнэтэй орон сууц юм. Урьдчилгаа 10-20% төлөөд байрандаа нүүж орох боломжтой тансаг зэрэглэлийг илтгэх, дотроо 2 давхар, void буюу 2 давхараас шууд харагдах хоосон орон зай бүхий Тансаг зэрэглэлийг илтгэх ДУПЛЕКС загварын орон сууц



- ЗГ-аас харагдуулж буй 8% зээлээ 7 хоногт шийдвэрлүүлэх:  
Та 100% ашиглалтанд орсон орон сууцнаас сонголт хийж, бидэнтэй хамтран ажилладаг Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хаан банк, Төрийн банкуудаар тусгайлан үйлчилгээг 8% зээлээ 7 хоногийн дотор шуурхай шийдвэрлүүлэх таатай боломжийг санал болгож байна.

- Албан байгууллага, хамт олноороо сонголт хийснээр адлах тусгай хөнгөлөлт:  
Хамт олноороо бэлэн болсон орон сууцнаас сонголт хийж үнийн хөнгөлөлт, авто машины зогсоолын хөнгөлөлт, Монтеессори сургалттай цэцэрлэгт хүүхдээ үнэгүй суралцуулах эрх зэрэг таны тав тухтай амьдрахад чиглэсэн бодит хөнгөлөлтүүдийг санал болгож байна.

- Бизнесмен танд зориулан уян хатан нөхцөл:  
Та өөртөө болон байгуулалтын хамт олондоо зориулан манай орон сууцнаас сонголт хийж, өөрийн эрхлэн явуулдаг бизнес болох барилгын сайн чанарын материалууд болон арматураар харилцан ашигтай хамтран ажиллах боломж бүхий таатай нөхцлийг санал болгож байна

- Банкны хүүгүйгээр өөрийн болгох боломж:  
Амжилтай яваа бизнесмен Танд зориулан өөрийн таалалд нийцсэн орон сууцныг бидний нэрлэсэн үнээр худалдан авч, төлбөрийн 50 хувийг төлөөд үлдэгдэл төлбөрөө 1-2 жилийн дотор хүүгүйгээр төлөх төлбөрийн нөхцлийг онцгойлон санал болгож байна.



Барилгын нэгдүгээр давхарт 24 цагийн харуул хамгаалалт, нэгдсэн лобби танхим бүхий таныг угтах ресепшн хэсэг, дулаан авто зосоол болон оршин суугчдын хэрэгцээг бүрэн хангах бүх төрлийн үйлчилгээний төвүүдийг төлөвлөсөн бүрэн цутгамал орон сууц юм.

ОРШИН СУУГЧДЫНХАА ТАВ ТУХ, ЭРҮҮЛ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭЖ ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ БРЭНДҮҮДЭЭР "X APARTMENT"-ЫГ ТОНОГЛОЛОО



Х-Апартментын хаяг: Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордоны зүүн урд талд

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд "УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ" ХХК өөрийн байранд

www.xapartment.mn

www.ubproperties.mn

УТАС: 88002312, 88030203

УТАС: 96066329, 77009919

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2459.00	2470.00	ФУНТ	2998.00	3101.00	АМ.ДОЛЛАР	2458.00	2468.00
ЕВРО	2623.00	2574.00	РУБЛЬ	36.50	39.50	ЕВРО	2591.00	2664.00
ИЕН	21.69	22.21	ЮАНЬ	354.40	359.40	ИЕН	21.81	22.45
						ФУНТ	3031.00	3115.00
						РУБЛЬ	36.85	39.71
						ЮАНЬ	354.00	359.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр  
Махаа  
импортлох бус  
экспортлооч

## Зөв замдаа орсон ч МӨЛХӨЖ БАЙГАА ИПОТЕКИЙН ЗЭЭЛЭЭ ЯАХ ВЭ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Төгсгөл.  
Түүрүүч нь I нүүрт

Нэг үгээр хэлбэл, Японы талаас хэдэнтэй манайд уг саналаа дайж иржээ. Харин нийслэлийн орлогч дарга нар нь “Манай хөдөө аж ахуйн салбарынхан дэмжинэ гэдэгт итгэж байна” гэх бөөрөнхий харилцааг асуудлаас зайлсхийдэг байх юм. Саяхан л гэхэд, Японы эзэн хаан Акихитогийн төрсөн өдрийн баярын цайллагын үеэр Японы Элчин сайдын яамныхан өнөөх л брэнд махыг ирсэн зочлоод амтлуулж, танилцуулах товхимолыг ч тарааж байв. Магадгүй энэ үйл ажиллагаа нь ч хариуцсан албаныхнаас эерэг хариу сонсоход нөлөөлнө гэж итгэснийх биз. Тэд үйлдвэрлэгч, экспортлогч улс. Тиймдээ ч, дэлхийн олон оронд танигдсан бүтээгдэхүүнээ манай зах зээлд нийлүүлэхийг санаархаж байна. Харин ямар хариу хэлэх нь манайхны сонголт. Гэхдээ гурван сая хүн амтай атлаа, 50 сая малтай монголчууд япон мах хэрэглэнэ гэвэл чихтэй бүхний хөх инээд хүрч мэднэ.

Японы хамгийн үнэтэй хүнсний нэг нь яах аргагүй үхрийн мах. 2000 жилийн нөр их хөдөлмөрөөр бий болгосон брэнд үхрийн мах нь гангич чулуу адил алагласан байх бөгөөд амт, чанар сайтай. Харин гол давуу тал нь ямар нэг нянгүй, эрүүл гэдэгт оршино.

### Н.ПУНЦАГБОЛД

Эхлээд нэг сүртэй тоо хэлье. Өнгөрсөн долоо хоногт “Гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах,

төгрөг төлчих чадалгүй л байв гэж. Ингээд бодохоор ядаж л одоо ашиглалтад нэгэнт орчихоод байгаа 30 мянган айлын орон сууцийг авчих эрэлт бол байгаа. Гагцхүү

суудаггүй байсан, зүгээр л улстөрийн намуудын амлалтаа биелүүлэх гэсэн муйхар алхмын нэг хэсэг. Хөтөлбөр нь маш зөв зүйтэй, харин шийдэх алхам нь тэнэг байсан гэсэн үг.

төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна. Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 10 дугаар сарын байдлаар 51.6 сая төгрөг байна гэсэн

“Төрийн банк”, “Хас” гэсэн 5-6 банкинд ногдож байна. Энэ дундаас арай гайгүй шалгууртайгаар, нааштай зээл өгч байсан нь Төрийн банк. Гэтэл хувьчлагдах сургаар

 **39400 ХАРИЛЦАГЧ НЭГДЭЭД БАЙНА** [www.HURIMTLAL.com](http://www.HURIMTLAL.com)  
хаягаар дансаа нээлгээрэй

Харин нүүдлийн соёл иргэншилт малчин монголчууд 21 зуун гарчихаад байхад малын гаралт халдварт өвчнөө ч эмчилж, шийдвэрлэж чадахгүй явсаар ийнхүү дотоодынхоо зах зээлийг ч булаалгах дээрээ тулал уу, янз нь. Өнгөрсөн жилийн тоон баримтаар Монголын нийт мал сүргийн тоо 50 сая давсан байх бөгөөд үүнээс 3.8 сая нь үхэр байв. Өргөн уудам тал нутагтаа дураараа бэлчээрлэж, шим гэжээлт өвс ургамлыг сонгон идэж, байгалийн хатуу бэрх дөрвөн ч ааш аягийг тэсвэрлэж тоо толгой нь улам өссөөр байгаа монгол үхрийн мах амт шингээрээ бусад орны “массаж хийлгэж, шар айраг ууж тансагладаг” үхрийг дагуулахгүй л болов уу.

Гэхдээ юмыг тааварлаж хэлэх аргагүй хойно хэрэв Япон үхрийн махаа манайх шиг жижиг зах зээлт улс руу экспортлолбол нэлээд үнэтэй байх нь гарцаагүй. Тодруулбал, тус улсад нэг бүтэн үхрийн мах нэг сая орчим иэнээр худалдаалагддаг юм билээ. Хамгийн сүүлийн үеийн ханшаар төгрөгийн иэнтэй харьцах ханш 22 болсон байв. Ингэж тооцвол нэг үхэр монгол мөнгөөр 22 сая орчим төгрөг болж байна. Гэхдээ мэдээж жингээсээ болоод үнэ нь өөр байх нь гарцаагүй. Махны чиглэлийн үхэр учраас эр үхрийг 400 орчим кг жинтэй гэж тооцвол нэг кг мах монгол мөнгөөр 60 гаруй мянган төгрөг болох нь.

Эдийн засгийн хямралд нэрвэгдэж, монгол үхрийнхээ махыг кг тутмыг нь 9000 төгрөгөөр худалдан авч ч чадахгүй байхад ийм хэмжээний өртөгтэй үхрийн махыг жирийн иргэд хэрэглэж чадахгүй л байх. Магадгүй баячуудын брэнд хэрэглээ болохыг үгүйсгэхгүй л дээ. Гэхдээ үүнээс нэг зүйлийг анзаарвал, бид малынхаа өвчнийг шийдвэрлэхийг бэлчээрийн органик шим тэжээлт махаа дээрх хэмжээний өртөгөөр гадаадын зах зээлд гаргах боломж байна. Үүн хэрэгтээ гадны орнууд ч манай малын махыг сонирхдог. Ганц тээг нь өвчин л байна. Эцэст нь, Япон брэндийг эх орон руугаа импортлох гэж зүтгэхийн оронд эхлээд малын гаралт өвчнөө шийдвэрлэхийг махны экспорт ярьвал яасан юм.

...Гэвч аравдугаар сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 31.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 56.9 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн аравдугаар сард 34.7 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийг санхүүжүүлэхэд өгч. Үүний 69.8 хувь буюу 24.2 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийнх, 30.2 хувь буюу 10.5 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна...

дахин төлөвлөхөд төрийн болон Олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг болсон. Энэ үеэр албан хүмүүс одоогийн байдлаар зах зээл дээр 80 мянган орон сууц байна. Түүний 30 орчим мянга нь бэлэн болчихсон, улсын комисс хүлээгээд авчихсан барилга гэсэн мэдээллийг өгч байсан. Үлдсэн 50 мянган орон сууц нь ямар хэмжээнд баригдаж байгаа гэсэн үг л дээ. Ойрын 1-2 жилийн дотор ядаж л 20 мянга нь бүрэн ашиглалтад орчих байх. Нөгөө талд Улаанбаатарын гэр хороололд 200 гаруй мянган айл өрх утаа үйлдвэрлээд л амьдарч байна. Тэдний ядаж л 25 хувь нь орон сууцанд ямар нэг байдлаар орох боломжтой байх. Бүгдээрээ л ямар ч орлогогүй, банкинд сардаа дунджаар 500 мянган

барилгачдын орон сууцаа зарах, иргэдийн авах “гүүр”-ийг холбож байсан ипотекийн зээл нь өөх ч биш булчирхай ч биш болчихлоо. МАН-ын Засгийн газар ипотекийн зээлийг эрүүлээр, зөв замаар урагшлуулаа гэж байсан ч одоогоор санаж сэрсэн юм алга. Яах вэ, ипотекийн зээл одоохондоо зөв замаар явж байна. Өнгөрсөн хугацаанд бол Монголбанкнаас мөнгө хэвлээд л ипотекийн зээлийг санхүүжүүлчихдэг байсан. Одоогоор ипотекийн зээл 3.95 тэрбум төгрөгт хүрчихээд байна. Үүний 3.05 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн хөтөлбөрийн зээл байгаа юм. Энэ мөнгөний ихэнхийг нь зүгээр л хэвлээд арилжааны банкуудад өгчихсөн. Энэ мөнгө төсөвт

Одоо бол Монголбанк мөнгө хэвлээд энэ хөтөлбөрийг санхүүжүүлэхгүй байгаа юм. Угаасаа тийм боломж ч байхгүй. Тэгэхээр одоо нэгэнт зээлчихсэн 3.05 тэрбум төгрөгөөс эргэн төлөлтөөр орж ирж буй 25 орчим тэрбум төгрөгийг буцааж зээлэх маягаар ипотекийн зээлийг санхүүжүүлж байна. Энэ бол одоохондоо энэ зээлийг хэрэгжүүлэх хамгийн зөв алхам. Угаасаа өөр мөнгө улсад байхгүй. Төв банк мөнгө хэвлэх алхмыг хийх ч боломжгүй.

Тиймээс эргэн төлөлтөөрөө ипотекийн зээлээ санхүүжүүлээд явахаас өөр арга байхгүй. Өнгөрсөн аравдугаар сард гэхэд банкууд 672 зээлдэгчид шинээр ипотекийн зээл олгосон байгаа юм. Түүний 419 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 253 нь банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна. Гэвч аравдугаар сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 31.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 56.9 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн аравдугаар сард 34.7 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийг санхүүжүүлэхэд өгч. Үүний 69.8 хувь буюу 24.2 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийнх, 30.2 хувь буюу 10.5 тэрбум

тоог Монголбанкнаас өгсөн мэдээлэлд дурьдсан байгаа юм. Ядаж байхад 34.7 тэрбум төгрөгийнх нь 23.2 хувийг нь хөдөө орон нутгийн зээлдэгчдэд өгчихсөн. Тэгэхээр Улаанбаатарт амьдарч байгаа иргэд орон сууцны зээлэнд ямархуу маягаар хамрагдаж байгаа нь тодорхой.

Ипотекийн зээлд Засгийн газрын ивээл дутаад байна

Монголбанк арваннэгдүгээр сард дээр дурьдсантай ойролцоо мөнгөнийг ипотекийн зээлийг санхүүжүүлэхэд зориулж арилжааны банкуудад өгсөн байж таараа. Удахгүй тайлан нь гарах байх. Гэхдээ тэндээс хараад байх шаардлага ч байхгүй. Хэрвээ ипотекийн зээлийн эргэн төлөлтөөр орж ирж байгаа мөнгөний л хуваарилсан бол 25 тэрбум хавьцаал байна. Тэгээд банкууд өөрсдийн эх үүсвэрээс хэдэн төгрөг нэмээд 30 гаруй тэрбумд л эргэлдэх учиртай. Ингээд л 700-гаад хүний зээлийн асуудлыг шийдэж өгч таарна. Өнөөдөр орон сууцны эрэлт ямар байгаа билээ. Хэдийгээр ипотекийн зээлийн санхүүжилт зөв замаар явж байгаа ч гэсэн арай л удаан байна. Мөхөж байгаа гээд хэлчихэд буруудахгүй. Ядаж байхад ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.5 хувь нь “ХААН”, “Голомт”, ХХБ,

зээлээ бараг хаачихлаа.

Одоо бол ипотекийн зээл өгч байгаа эсэх нь ч мэдэгдэхгүй шахам л байна, банкууд. Угаасаа ипотекийн зээлийн шалгуур ямар өндөр билээ. 30 хувиа яаж бүрдүүлсэнэ батлахаас авахуулаад бөөн юм болдог. Гэтэл одоо санхүүжилтэд нь өгч байгаа мөнгөний хэмжээ өнгөрсөн жилийнхээ даруй 60 хувиар буурчихаар хэнд зээл олдох вэ дээ, ойлгомжтой. Тийм болохоор одоо МАН-ын “Мэргэжлийн” Засгийн газар энэ асуудалд жаахан анхаарлаа хандуулж, хайр ивээлээ хайрлаач ээ. Анхаарал хандуулаач гэхээр төв банкаас мөнгө хэвлэж гэж шахааж болохгүй. Гаднаас хөрөнгө оруулалт татаж, түүнийгээ улсын төсөвт суулгах замаар ипотекийн зээл рүү орж байгаа мөнгөний жаахан нэмэхгүй бол ойрын хэдэн жилдээ хурд нь нэмэгдэхгүй, сардаа 500 орчим хүний асуудлыг л шийдсээр байх болчихоод байна. Магадгүй 2020 он хүртэл энэ янзаараа, яст мэлхийн хурдаар урагшлах болчихоод байгаа юм. Гэтэл тэр хооронд өнөөх зах зээл дээр байгаа 80 мянган айлын орон сууц чинь бүгд бүрэн ашиглалтад ороод дуусчих байх. Харин иргэд орон сууц авч чадахгүй хэвээрээ л байна. Өнөөх утаа, хөрсний бохирдол нь улам нэмэгдэх нь ойлгомжтой. Тийм болохоор яст мэлхийн хурдтай ипотекийн зээлийнхээ “алхаа”-г нэммээр байна.

 **УРИАЛГА**

Ардчилсан Монгол Улсыг байгуулах үйл хэрэгт хүчин зүтгэж, ардчиллын үнэт зүйлийг тээж, үзэл санааг дэмжиж ирсэн намынхаа гишүүд, дэмжигчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

26 жилийн түүхтэй Монголын Ардчилсан намын ололт амжилт бүхэн бидний түүхийг бүтээж байгаа билээ. Энэ хугацаанд бид амжилтаараа бахархаж,

бас алдаа оноогоо дүгнэн хэлэлцсээр ирлээ. Ардчилсан намын VI Их хурал 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдөр болно. Ардчилсан намын шинэчлэлийн төлөө Ардчилсан намын VI Их хурлын ажиллагааг дэмжиж, ардчиллыг бататгахын төлөөх үйлст хандив өргөж, дэмжин ажиллахыг намынхаа нийт гишүүд болон дэмжигчдэдээ уриалж байна.

**Ардчилсан намын VI Их хурлыг зохион байгуулах ажлын хэсэг Хангивын данс: Голомт банк, 1205119109 Ардчилсан нам.**

# ДЭЛХИЙ



# ПАК ГЫН ХЕ: Би огцроход бэлэн байна

## Тайландын шинэ хаан сэнтийдээ заларна

Тайландын Засгийн газар тус улсын ханхүү Маха Важирапонкорнын хаан ширээнд залах талаарх журмыг боловсруулж эхэлжээ. Дэлхийн хамгийн удаан хугацаанд хаан ширээнд заларсан эзэн хаан гэгдэж явсан тус улсын Пхумипон Адулядет хаан өнгөрсөн сарын 13-ны өдөр өвчний улмаас 88 насандаа таалал төгссөн юм. Эзэн хаан таалал төгссөнөөс хойш сар гаруйн хугацаанд хаан ширээ залгамжлах бэлтгэл ажлыг холбогдох албаныхан хангаж иржээ. Тэгвэл энэхүү бэлтгэл ерөнхийдөө хангагдаж, тун удахгүй Ерөнхий сайдын нарийн бичгийн дарга хунтайжийг хаан ширээнд залах талаарх журмыг УИХ-д өргөн барихаар болсон байна. Журмыг УИХ-ын дарга хүлээн авсны дараа албан ёсоор хунтайжийг хаан ширээнд өргөмжлөх бөгөөд үүний дараа ард иргэдэд шинэ хааныг танилцуулах ажээ. Тайландын угсаа залгамжлах хунтайж эдүгээ Германд амьдарч байгаа юм.

## Дэлхийн хамгийн өндөр настан эмэгтэй 117 нас хүрлээ

19 дугаар зуунд төрсөн хамгийн сүүлчийн амьд хүн буюу манай гаригийн хамгийн өндөр настан өчигдөр 117 насныхаа төрсөн өдрийг тэмдэглэжээ. Италийн иргэн Эмма Морано 1899 оны арваннэгдүгээр сарын 29-ний өдөр төрсөн бөгөөд дэлхийн хамгийн өндөр насалсан хүнээр нэрлэгддэг билээ. Тэрбээр өнгөрсөн сард Италийн хойд этгээдийн Маггиоре нуурын эрэгт байрлах Вербана дахь гэртээ “франц пресс” агентлагийн сурвалжлагчдад ярилцлага өгсөн байдаг. Улмаар энэ үеэр урт насалсан нууцаа ярьжээ. Эмма Морано “Өдөр бүр ердөө хоёрхон өндөг иддэг. Дараа нь хоол иднэ. Гэхдээ шүдний болсон болохоор тийм ч их хоол идэж чаддаггүй” гэж ярьжээ. Нэлээд яриа хүний тоонд багтах тэрбээр амьдралынхаа ихэнх хугацааг ганцаарал дунд өнгөрүүлжээ. Ганц хүүгээ нялхаар нь алдсаныхаа дараа удалгүй 1938 онд харгис нөхөр нь өөд болсноос хойш Морано шуудайны үйлдвэрт ажиллаж, өнөөдрийг хүртэл ганцаараа амьдарчээ. Нас сүүдэр аль хэдийнэ 100 гарсан учир хараа, сонсгол нь муудсанаас гадна ярихад ч хүндрэлтэй болсон гэнэ. Тиймээс зурагт үздэггүй төдийгүй өдрийн ихэнхийг унтаж, хоолож өнгөрүүлдэг байна.

...Пак “Үндэсний ассамблей миний Ерөнхийлөгчийн албыг хаших хугацааг богиносгох, эсвэл огцруулах ямар ч шийдвэр гаргасан бай, би тэдний шийдвэрийг дагах болно...”

### БДАВААХҮҮ

БНСУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч хэмээн дэлхий дахинаа танигдсан Пак Гын Хе найзыгаа улс төрийн үйл хэрэгтээ хөндлөнгөөс оролцуулсан гэх дуулианд нэр холбогдож, тус улсын анхны “Гэмт хэргийн сэжигтэн Ерөнхийлөгч” болоод буй билээ. Эцэг, эхээ цаг бусаар алдсан хүнд хэцүү цаг үед нь түшиг тулгуур болж явсан гэх түүний дотны найз Чой Сун Шил Ерөнхийлөгчтэй дотно байдлаа ашиглан өөрийн байгуулсан соёл, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сандаа томоохон корпорацудаас их хэмжээний мөнгийг хандив нэрийддээр төвлөрүүлсэн нь ил болж, саатуулагдаад буй. Авлигын хэргийн дуулиан дэгдэж эхэлмэгц сэжигтний компьютерээс Пак Гын Хе Ерөнхийлөгчийн түүн рүү илгээсэн улс төрийн чанартай нууц материалууд

олдсон байдаг. Ингэснээр Ерөнхийлөгч Чой Сун Шил гэгчийн утсан хүүхэдтэй төдий байж ирсэн нь ийм хэмжээний хөрөнгийн авлига авах нөхцлийг бүрдүүлжээ гэх шүүмжлэл ч нийгэмд хүчээ авч эхэлсэн билээ. Ерөнхийлөгч өөрөө ч хоёр удаа ард түмэндээ хандсан мэдэгдэл хийж, хэлэх үгээ найзаараа засварлуулж байснаа хүлээн толгой гудайлган өршөөл хүссэний зэрэгцээ шаардлагатай тохиолдолд байцаалт өгнө гэдгээ илэрхийлсэн. Гэхдээ хуульд зааснаар төрийн эрх барьж буй Ерөнхийлөгч байцаалт өгөх боломжгүй байдаг бөгөөд Пак ч бие төлөөлөгчөөрөө дамжуулан хэргийн талаар мэдүүлэг өгөхөөс татгалзсан удаатай. Дуулиан дэгдсэнээс хойш сар орчим хугацаанд БНСУ-ын иргэд ч хэд хэдэн удаагийн томоохон эсэргүүцлийн жагсаалыг зохион байгуулсны зэрэгцээ улс төрийн жижиг

хүчнүүд ч үүсээд буй нөхцөл байдлыг ашиглан эрх баригч Сэнури намын рейтингийг унагахыг оролдож эхэлсэн юм. Сөрөг хүчнийхний зүгээс Пак Гын Хе өөрийн хүслээр албан тушаалаасаа огцрохыг удаа дараа шаардсан. Улмаар өнөөдөр Үндэсний ассамблейд өнөөгийн Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх талаар санал хураалт явуулах суулийн төслийг өргөн барихаа мэдэгдсэн билээ. Парламентаар уг асуудлыг энэ баасан гарагт хэлэлцэх юм. Тэгвэл ард иргэдийнхээ ширүүн эсэргүүцэлтэй нүүр тулгараад буй Ерөнхийлөгч Пак Гын Хе асуудлыг шийдвэрлэх гарцыг парламентад үлдээхийг хүсчээ. Тодруулбал, тэрбээр энэ баасан гарагт болох парламентын хуралдааны үеэр гишүүд түүнийг суудлаас нь буулгахыг хүсвэл огцроход бэлэн байгаагаа мэдэгдсэн байна. Пак “Үндэсний ассамблей миний Ерөнхийлөгчийн албыг хаших хугацааг богиносгох,

эсвэл огцруулах ямар ч шийдвэр гаргасан бай, би тэдний шийдвэрийг дагах болно. Хэрэв үндэсний ассамблей улс төрийн эмх замбараагүй байдал, хий хоосон улстөржилтийг шийдвэрлэхийн тулд эрх мэдлийг тогтвортойгоор шилжүүлнэ гэвэл би Ерөнхийлөгчийн албан тушаалаасаа огцроход бэлэн байна” гэжээ. Хэдэн долоо хоногийн турш нийслэл Сөүл хотноо сая сая солонгосчууд Ерөнхийлөгчөө огцрохыг шаардан жагссаны дараа үндэсний телевизээр хийсэн мэдэгдэлдээ тэрбээр ийнхүү ярьсан байна. Ирэх жил Ерөнхийлөгчийн халаагаа өгөх Ерөнхийлөгч Пак Гын Хе, түүний найз Чой Сун Шил нарын хэрэгт Солонгосын нэр нөлөө бүхий компаниуд болох Lotte, Samsung гэх мэт долоон компани холбогдоод буй бөгөөд Пак Гын Хэгийн хоёр туслахыг мөн баривчлан, байцааж эхлээд буй юм.

## Самсунг электрониксыг хоёр хуваана

БНСУ-ын Самсунг Электроникс компани сүүлийн үед ихээхэн алдагдал хүлээх болсонтой холбоотойгоор бүтцийн өөрчлөлт хийж, хоёр тусдаа компани болон хуваагдах боломжийг судалж буйгаа өчигдөр олон нийтэд мэдээллээ. Энэ нь өнөөгийн дэд Ерөнхийлөгч Ли Жэ Ён компанийн захирлын суудлыг эцгээсээ залгамжилж буйтай холбоотойгоор хийгдэж буй бүтцийн өөрчлөлт байх магадлалтайг зарим эх сурвалж онцолж байгаа

юм. Зарим хувьцаа эзэмшигчид ялангуяа АНУ-ын томоохон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч "Elliott Management" компани "Samsung Electronics"-т бүтцийн өөрчлөлт хийж, хоёр хуваан нэг хэсгийг үндсэн нэгж, нөгөө хэсгийг хувьцаа эзэмшигчдэд зориулах санал тавьсаны дагуу дээрх шийдвэрийг гаргажээ. Тус компани хувьцаа эзэмшигчдийн уялдаа холбоог сайжруулж, цаашдаа илүү их хувьцаа худалдаж авах төлөвлөгөөтэй байгаа аж. Тус

компани “Галакси нөүт 7” гар утасны баттерэй дэлбэрсэн гэх томоохон асуудлын улмаас ухаалаг гар утасны салбартаа тэргүүлэгч Самсунгын шинэ бүтээгдэхүүний борлуулалтдаа алдагдал хүлээсэн билээ. Ямартай ч, Самсунг электроникс хувьцаа болон үйлдвэрлэл үйлчилгээний гэсэн хоёр хэсэгт хуваагдах асуудлыг эдүгээ судалж буй бөгөөд судалгаа шинжилгээний ажилд зургаан сар орчим хугацаа зарцуулна гэдгийг албаныхан мэдэгдлээ.



## Дмитрий Песковын эхнэр дуулиан тарилса

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины ойрын хүн гэгддэг Ерөнхийлөгчийн тамгын газрын хэвлэл мэдээлэл хариуцсан нарийн бичгийн дарга Дмитрий Песковын эхнэр Холокост /еврейчүүдийг хомроглон устгах/-оос сэдэвлэсэн үзүүлбэр үзүүлээд цахим ертөнцөд дуулиан тарьжээ. Песковын эхнэр Өвлийн олимпын алтан медальт

уран гуллагч Татьяна Навка саяхан олны танил алдартнуудын цэнгээнт нэвтрүүлэгт оролцож, жүжигчин Андрей Бурковскитай хослож, нэгэн содон үзүүлбэр үзүүлсэн гэнэ. Тодруулбал, тэд нацист германы үеийн бөөнөөр хорих лагерийн хоригдлуудын өмсдөг хар, цагаан босоо судал бүхий хувцас өмсч, тухайн цаг үеийн

нөхцөл байдлыг тоглоом мэтээр тайлбарлаж, эцэстээ амь үрэгдэж буй тухай өгүүлсэн байдаг билээ. Татьяна Навкагийн оролцсон нэвтрүүлэг Оросын нэгдүгээр сувгаар гарчээ. Улмаар түүний үзүүлбэр шүүгчдээс хамгийн өндөр оноо авч, мөн магтаал хүртсэн байна. Харин дараа нь Татьяна өөрийн инстаграмм

хуудастаа “Миний хамгийн дуртай уран бүтээлийн минь нэг. Бидний үр хойч тэрхүү эмгэнэлт цаг үеийн тухай мэдэх ёстой. Бас хэзээ ч мартаж ёсгүй” хэмээн сэтгэгдлээ үлдээсэн байна. Гэсэн ч, түүний үзүүлбэр эдүгээ дэлхийн нийгмийн сүлжээнд хүчтэй тархаж, хэрүүлийн алим болж эхэлжээ.

## Зорчигч тээврийн онгоц сүйрч, зургаан хүн л амьд үлджээ


Колумбын томоороо хоёрт орох Меделлин хотыг чиглэн ниссэн 81 зорчигчтой ЛАМИА Боливиа авиа компанийн СР2933 нислэгийн дугаартай зогчигч тээврийн онгоц сүйрчээ. Хамгийн сүүлд авсан мэдээллээр тус ослоос ердөө зургаан хүн л амьд үлдсэн гэнэ. Онгоцны зорчигчдын ес нь нисэх багийн гишүүд байсан бол үлдсэн нь зорчигчид байжээ. Тэдний дунд Бразилын холбөмбөгийн “Charcoense” багийн тамирчид багтаж байсан аж. Ослын бүсэд зорчигчдыг аврах ажиллагаа үргэлжилсээр байгаа бөгөөд цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас аврах багийнхан ослын газарт хүрэхэд бэрхшээлтэй нөхцөл байдал үүсээд буйг зарим эх сурвалж мөн онцолж байна. Боливинс хоёрсон онгоц Меделлинээс 50 орчим км зайтай Серро Гордо гэх хотын ойролцоо нисч явахдаа сүйрчээ. “Charcoense” багийн тамирчид ирэх сарын 1-нд Колумбын “Атлетико Насьональ” багтай “Copa Sudamericana-2016” тэмцээний шийдвэрлэх тоглолтыг хийх байсан ч, ийнхүү харамсалтайгаар осолд оржээ.

MINFO АПП  
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAХ PLAY STORE    TATAХ APP STORE

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out



# ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨСӨЛТӨД БИД БҮГДЭЭРЭЭ БУРУУТАЙ

Н.ПУНЦАГБОЛД

Хэвлэлийн хүрээлэнгийн дэргэдэх Эдийн засгийн “Өөрчлөгч” клубээс “Валютын ханшийн огцом хэлбэлзэл, тогтворжуулах арга замууд” хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Б.Лхагважав, Монголбанкны ахлах эдийн засагч Б.Түмэнцэнгэл, судлаач А.Мөнхцог нар оролцож байр сууриа илэрхийлсэн юм. Тэдний хэлснээр валютын ханшны өсөлтөд төр, ард иргэд, аж ахуй нэгжүүд бүгдээрээ буруутай болж байна. Судалгааны дүнгээс харахад, иргэд, эдийн засагчид хүртэл ам.долларын ханш өснө гэсэн хүлээлттэй байгаа ажээ.

Гэрэл зургийг Г.АРТУУЖИHN



**Б.Лхагважав:**Зах зээлд 1.5 их наяд төгрөг тарааснаас болж ам.доллар 3000 төгрөгт хүрсэн

*/Худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч/*

-Төгрөгийн ханшийн сулралд хоёр хүчин зүйл нөлөөлсөн гэж харж байна. Нэгд, өмнөх Засгийн сонгуулийн өмнөх амлалт буюу иргэдийн хувьцааг худалдан авч байна гэх нэрээр зах зээлд 1.5 их наяд төгрөгийг

хэвлээд тараачихсан. Үүний нөлөөгөөр ам.долларын ханш 3000 төгрөг рүү дөхсөн. Хоёрт, Эрдэнэтийн том наймааны асуудал ханшид нөлөөлсөн гэж харж байгаа. Нэг талаас Эрдэнэт 100 хувь Монголын эзэмшилд ирсэн гайхамшигтай үйл явдал болсон. Нөгөө талд Эрдэнэтийн 49 хувийг худалдан авалт нь эргээд Монгол Улсын мөнгөний бодлогод гай тарьсан. Монголын зах зээлээс 483 сая ам.доллар бэлнээр долоо хоногийн хугацаатай гаргаж, ОХУ-ын компанид төлсөн. Энэ худалдааг хийхэд яагаад мэргэжлийн байгууллагууд нь оролцсонгүй вэ, Төв банк ийм хэмжээний эх үүсвэр

зах зээлээс гарч байхад яагаад чимээгүй байсан бэ. Өнөөдрийн валютын хомсдолын гол шалтгаан нь Эрдэнэтийн 49 хувийн худалдан авалт байсан. Энэ өр төлбөрийг яагаад заавал нэг дор бэлнээр төлөх ёстой байв. Яагаад 3-4 жилийн хугацаатайгаар цувуулж төлж болоогүй юм бэ. Энэ бүхэнд Монголбанк болон эрх баригчид хариулах ёстой. Өнөөгийн нөхцөл байдалтай холбогдуулан валютын зээлтэй аж ахуйн нэгжийн зээлийн гэрээ хэлцлийг эргэн харж, аль аль талдаа ашигтай байдлаар зохицуулах уриалгыг танхимаас гаргасан. Үүний дагуу төрөөс болон

Монголбанкны зүгээс үр дүнтэй арга хэмжээ авахыг хүлээж байна. Цаашид төр засаг том өмчийн худалдаагаа ил тод явуулах хэрэгтэй. Том өмчлөлийн асуудал нууц явснаас өнөөдөр төгрөгийн ханш огцом унасан. Тэгэхээр энэ асуудал дээр анхаарах хэрэгтэй. Ирэх онд Эрдэнэтийн 49 хувийг худалдан авсантай тэнцэх өрийг Хөгжлийн банк төлнө. Энэ үед дахиад ханшид савлагаа үүсэхийг үгүйсгэхгүй байна. Мөн шахахууны үнийг сулрааж, чөлөөт зах зээл рүү нь тавьбал зах зээлд маш том тэсрэлт гарна. Үүнийг хэрхэн зохицуулах вэ. Үүнийхээ эсрэг ажиллах мэргэжлийн

баг, судлаачдыг ажлуулах хэрэгтэй байна. Дээр нь Засгийн газар, Монголбанкны авч хэрэгжүүлэх арга хэмжээ маш удаан байна. Үүнээс болж гадаад битгий хэл дотоодын хөрөнгө оруулагчид бизнесээ төлөвлөж чадахгүй, маш хүнд нөхцөлд ажиллаж байна. Тиймээс Засгийн газар, Монголбанк зах зээлд нөлөөлөх оновчтой шийдвэр, арга хэмжээг авах хэрэгтэй. Өнөөгийн байдлыг харахад маш удаан ажиллаж байна.



**Б.Түмэнцэнгэл:** Зах зээлд тодорхойгүй байдал үүссэнээс ханш өсч байна

*/Монголбанкны ахлах эдийн засагч/*

-Валютын ханшийн огцом савлагаа монгол хүн бүрийн санааг зовоосон асуудал болж байна уу гэвэл тийм. Энэ асуудалд Засгийн газар,

УИХ, Монголбанк, хувийн хэвшлийнхэн, тэр битгий хэл энгийн иргэд ч анхаарах ёстой. Ханшийн савлагаанд гурван шалтгаан байна. Нэгд, уул уурхайгаас хамаарсан эдийн засагтай байгаа нь нөлөөлсөн. 26 жилийн хугацаанд бид экспортлогч улс болж чадсангүй. Өнөөдөр 2016 онд экспортын 90 гаруй хувийг уул уурхайн хагас боловсруулсан бүтээгдэхүүн эзэлж байна. Энэ сайжраагүй цагт Монгол руу орж ирэх валютын урсгал тодорхой хэмжээнд хязгаарлагдмал

байна. Хоёрт, дэд бүтцийн сул хөгжил. Зах зээлд хэн хэдийг хэмжээний доллар зарж, хэн хэдийг авах нь илүү тодорхойгүй байна. Зах зээлд тодорхойгүй байдал үүссэнээс ханш өсч байна. Монголбанк ирэх жил ханшийн платформыг шинэчлэх, валютын зах зээлийг тодорхой нээлттэй болгоход чиглэн ажиллана. Манай улсын төлбөрийн тэнцэл 2013 оноос алдагдалтай гарч байгаа. 2016 оны эхний хагаст 700 сая ам.долларын эх үүсвэр орж ирсэн ч эргээд 500 орчим

ам.доллар гарсан нь ханшид огцом нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Монголбанкны хуулийн дагуу гэрээ хэлэлцээрээр зохицуулагдаж байгаа валютын орох, гарах урсгалыг хянах боломжгүй байгаа. Монголбанкинд нэг тэрбум ам.долларын гадаад валютын нөөц байна. Энэ нь огцом хэлбэлзлийг хаах хэмжээний эх үүсвэр. Богино хугацаанд ханшийн хүлээлт эерэг хандлагатай байна. Учир нь, энэ долоо хоногоос ам.долларын ханшийн өсөлт саарах төлөв ажиглагдаж

байгаа. Цаашид Засгийн газар болон Монголбанкны олон улсын байгууллагуудтай хийж буй гэрээ хэлэлцээрийн үр дүнгээс хамаарч урт хугацаандаа ханш тогтворжих боломжтой. Нэг зүйлийг нэмж хэлэхэд ханшийн алдагдал хүлээж байгаа аж ахуйн нэгжүүд болон банкны валютын зээлийн асуудалд Монголбанк шууд оролцох боломжгүй байгаа.



**А.Мөнхцог:** Иргэдийн ам.долларын ханш өснө гэсэн хүлээлт эрэлтийг нэмэгдүүлж, ханшийг хөөсрүүлж байна

*/Монголын хөрөнгийн зах зээлийн зөвлөлийн судлаач/*

-Монголын хөрөнгийн зах зээлийн зөвлөлөөс хараат бус

ам.долларын ханш цаашид яах вэ гэдэг санал асуулгыг олон нийтийн дунд явуулсан. Олон нийт гэдэг маань иргэд, судлаачид. Энэ судалгааны үр дүнгээс танилцуулах гэж энд ирсэн. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 56 хувь нь ам.долларын өсөлтийг хөөрөгдөлт байна гэж үзсэн. Харин судлаачдын 62 хувь нь ам.долларын өсөлт зах зээлийн зарчмаараа биш зохиомлоор хөөрөгдсөн гэж үзэж байгаа юм. Харин ам.долларын ханш цаашид

яах вэ гэдэг асуултад иргэд болоод судлаачдын 62 хувь нь он дуустал өснө гэж үзсэн. Тэгвэл 2017 оны хавар гэхэд ам.долларын ханш яах вэ гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 40 гаруй хувь нь оны төгсгөлд хүрсэн төвшнөөсөө өснө гэсэн. Харин 2017 оны арванхоёрдугаар сард буюу жилийн төгсгөлд ам.долларын ханш ямар байна гэсэн хүлээлттэй байна вэ хэмээн асуухад иргэдийн 32, судлаачдын 30 хувь нь өснө гэж хариулсан. Иргэдийн

дунд ам.долларын ханш өснө гэсэн хүлээлт илүү давамгайлж байна. Хүлээлтээс үүдэн ам.долларын эрэлт нэмэгдэж зах зээлийн ханшид хөөс үүсч байгаа дүр зураг харагдаж байна. Тиймээс иргэдийн хүлээлт рүү чиглэсэн мэдээлэл ханшид эерэгээр нөлөөлөхийг үгүйсгэхгүй. Судалгаанд оролцогсдын тал хувь нь ам.долларын өсөлт зохиомол гэж хариулж байгаа нь хардлага байгаа гэсэн үг. Тиймээс бид юуны өмнө мөнгөний захаа нээлттэй

болгох хэрэгтэй байна. Монголбанкны төлөөлөгч хэллээ, бид платформоо янзалж байгаа, мөнгөний захыг биржтэй болгох гэж байгаа гэж. Энэ бүхэн ажил хэрэг болоод, мөнгөний зах нээлттэй болж, хэн яг хэдээр зарж байгаа юм гэдэг тодорхой болоод ам.долларын ханш зах зээлд дээр тогтоод эхэлбэл хөөсрөлт байхгүй болно.



Тал нутгийн цахим мэдээлэл



## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## Итгэл дагуулах

Төгсгөл.  
Түүрч нь I нүүрт

Нэг үгээр хэлбэл, их сургуулийн Сургалтын эмнэлэг хотын зүүн хэсэг дэх шинэхэн байрандаа анагаахын оюутнуудад сургалтын бааз болохын хамт иргэдэд нэгдсэн эмнэлгийн болоод улсын хэмжээнд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Гэхдээ одоо ч гэсэн Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэгт их үйлс өрнөж байгаа гэдгийг энд онцолъё.

АШУУИС-ийн нэгдүгээр давхарт байрлах Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэгт өөрийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх гэж мөрийх резидент эмч нар, оюутнуудад өөрийн мэдлэгээ харамгүй хайрлахаас гадна хүн ардынхаа



Гэрэл зургийг Г.АРГУУЖИHN



эрүүл мэндийн төлөө эмнэлэгт нь хандан ирсэн өвчтөн бүрийг үзэхгэсэндоктор, профессорууд хурдан хурдан алхалж, басхүү олон жил ажилласан, туршлагатай анагаах ухааны доктор, профессоруудад үзүүлэх гэсэн иргэдийн урт гэгч дараалал үүсч, нөгөөтэйгүүр олон улсын техник, технологи, үйлчилгээний арга барилыг нэвтрүүлэхээр зэхэж байгаа шинэ байрандаа орох бэлтгэл ажлыг гүйцэтгэхээс эхлээд энд ажил, амьдрал, их үйлс эд өрнөж буй. Тиймээс “Монголын

бидний үлгэрийн далай мэт бодож, сэтгэж явсан тэр их бүтээн байгуулалт нүдний өмнө биеллээ олж, өнөөдөр олонд хэдийнэ танигдсан эмнэлэг болжээ. Ингэж хэлсэн учир гэвэл манай сурвалжлах хэсэг өглөөний 10:00 цагтай уралдан тус эмнэлэгт очиход эмч бүрийн өрөөний үүдэн дэх сандгууд эзнээ олж, үзүүлэх гэсэн үйлчлүүлэгчдийн хөлд даргадсан байлаа. Эмнэлгийн хаалгаар дөнгөж ороод баруун гар талд угтагч сувилалчийн хүлээн авах хэсэг байрлах

зөвлөх поликлиникийг гастероэнтерологи, дурангийн тасаг, дүрс оношлогооны тасаг, Мэдрэл судлал, үйл оношийн тасагтайгаар байгуулан ажилласан нь эдүгээ их сургуулийн нэгдсэн эмнэлгийн эхлэл байжээ. Сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлгийн үйлчилгээний нэгдлийг хангасан “Их сургуулийн эмнэлэг”-ийн үндэс суурийг тавих зорилгоор АШУУИС-ийн захирлын 2008 оны нэгдүгээр сарын 23-ны өдрийн А/06 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургуулиудын харьяа эмнэлгийн үйлчилгээ эрхэлж буй тасаг, нэгжүүдийг нэгтгэн “Эрхэс” эмнэлгийг байгуулсан гэнэ. Ийнхүү үйл ажиллагаа өргөжихийн хэрээр “Эрхэс” эмнэлгийн захиргааны санаачилга, АШУУИС-ийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн яаманд хүсэлт гаргасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2012 оны долдугаар сарын 4-ний өдрийн 233 тоот тушаалаар улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Их сургуулийн Нэгдсэн эмнэлэг болжээ. Энэ дагуу зүрх, бөөр, дотоод шүүрэл, уушиг, гастроэнтерологи, гепатологи, дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, чих хамар хоолой, нүд, уламжлалт, сэргээн засах, урологи, хөнгөвчлөх, арьс, мэс засал зэрэг нарийн мэргэжлийн кабинет, дуран, дүрс оношлогоо, лабораторийн тасгууд болон дотор, мэдрэл, мэс заслын 40 ортой хэвтүүлэн эмчлэх тасаг бүхий нэгдсэн эмнэлэг, 50 ортой клиник сувилалтай болон өргөжсөн тухухтэй ажээ. Энэ талаар Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Д.Даваадорж “Манай эмнэлэг АШУУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын эрдэмтэн, профессор, багш нарын оролцоотойгоор өвчин эмгэгийг олон улсын төвшинд оношлох, эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад авах, зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх үзлэг хийж байна. Мөн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Энэ эмнэлгийг байгуулах олон шалтгаан байсан. Түүний нэг нь эмч, мэргэжилтнүүд болон шинэ залуу боловсон хүчинг

бэлтгэх, резидент эмч нарыг чадавхжуулах, мэргэшүүлэх байлаа. Ер нь олон улсад анагаахын мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиуд өөрсдийн гэсэн сургалтын бааз эмнэлэгтэй байдаг. Бидэнд ч бас өөрийн сургалтын бааз эмнэлгээр дамжуулан эмч, мэргэжилтнүүдээ бэлтгэх шаардлага тулгарсан. Эмнэлэг байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж байна. Энэ жил гэхэд долоон чиглэлээр үйл ажиллагаа үзүүлэх, нэгдсэн эмнэлгийн зөвшөөрлөө Эрүүл мэндийн яамнаас авлаа. Энэ сургуулийн эмнэлзүйн багш, эмч, ажиллагсдын хөдөлмөрийн үр дүнд сургалтын бааз эмнэлэг маань хөл дээрээ баттай зогсож, өөрийн гэсэн үйлчлүүлэгчтэй болж тодорхой хэмжээнд олонд танигддаг явж байна. Энэ бол манай эмнэлзүйн багш нар, эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөрийн үр дүн” хэмээв. Мөн цаашид их сургуулийн профессор, багш нарын чадварлаг багаар орчин үеийн тоног төхөөрөмж, шилдэг технологид тулгуурлан олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлдэг эмнэлзүй, сургалт, эрдэм шинжилгээний цогц их сургуулийн нэгдсэн эмнэлэг болгохоор ажиллаж буй ажээ. Түүнийг ийнхүү бидэнтэй ярилцах зуур утас нь хэд хэдэн удаа дуугарсан нь үзүүлэх гэсэн үйлчлүүлэгчдийн дараалал аль хэдийнэ үүссэнийг илтгэнэ. Тиймээс бид Д.Даваадорж захирлыг удаан уяхыг хүссэнгүй. Түүнтэй хамт дурангийн тасаг руу явлаа. Энд Д.Даваадорж захирал дурангийн оношлогооны чиглэлээр мэргэшсэн анагаах ухааны доктор, профессор бөгөөд эмнэлэгтэй ажиллахын зэрэгцээ АШУУИС-даа багшилдаг гэдгийг энд онцолъё.

...Одоогоос хэдэн жилийн өмнө Анагаахын сургуулийн дэргэд сургалтын лаборатори эмнэлэг байгуулна гэхэд чихтэй болгоны хөх инээд хүрч байсан. Ингэх нь ч арга үгүй. Хатуухан хэлэхэд, манай улсын гэсэн тодотголтой их сургуулиуд хажуудаа лаборатори эмнэлэг байгуулах нь бүү хэл урсгал засвараа хийж чадалгүй толгой гашилгаж суудаг байсан нь нууц биш. Тиймээс хүн бүхэнд л биелэгдэшгүй үлгэр мэт санагдсан биз. Тэгвэл бидний үлгэрийн далай мэт бодож, сэтгэж явсан тэр их бүтээн байгуулалт нүдний өмнө биеллээ олж, өнөөдөр олонд хэдийнэ танигдсан эмнэлэг болжээ...




мэдээ сонин” Монголдоо анхдагч хэмээх АШУУИС-ийн Их Сургуулийн Сургалтын нэгдсэн эмнэлгээс энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ.

Их сургуулийн сургалтын эмнэлгийн үйл ажиллагаа Нэгдсэн эмнэлгийн хэмжээнд хүрчээ

Одоогоос хэдэн жилийн өмнө Анагаахын сургуулийн дэргэд сургалтын лаборатори эмнэлэг байгуулна гэхэд чихтэй болгоны хөх инээд хүрч байсан. Ингэх нь ч арга үгүй. Хатуухан хэлэхэд, улсын гэсэн тодотголтой их сургуулиуд хажуудаа лаборатори эмнэлэг байгуулах нь бүү хэл урсгал засвараа хийж чадалгүй толгой гашилгаж суудаг байсан нь нууц биш. Тиймээс хүн бүхэнд л биелэгдэшгүй үлгэр мэт санагдсан биз. Тэгвэл

бөгөөд ирсэн хүн бүртэй эелдгээр мэндчилж, эмчийнх нь өрөө, шинжилгээ өгөх газрыг зааж өгөхөөс эхлээд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг аж. Эмнэлгийн байгууллага болоод ч тэр үү өрөө тасалгаа бүр цэвэр цэмцгэр, тохилог агаад дотор ажиллагсад, үйлчлүүлэгчид ч нарийн дэг журамтай байв. Ирсэн үйлчлүүлэгчдийн ихэнх нь цэнхэр өнгийн гялгар улавч өмсөж, зарим нь нэг удаагийн халад нөмөрсөн байхыг харахад энд эмнэлгийн ариун цэврийг нямбайлан сахидаг нь тодорхой байлаа. Эмнэлгийн хаалгаар анх ормогч л биднийг нийм нэгэн төрх байдал угтсан юм. Манай сурвалжлах хэсэг завгүй ажиллах эмч нар, дугаараа хүлээн зогсох үйлчлүүлэгч нарт саад хийхийг хүсээгүй учраас юун түрүүнд тус эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Д.Даваадоржтой уулзаж, эмнэлгийн түүхэн замнал болоод цаашдын зорилго чиглэл, хийгдэж байгаа үйл ажиллагааны талаар ярилцсан юм. Анх 2007 онд АУС-ийн харьяа “Эрхэс”



Бодит практикт суурилсан чанартай сургалт

Манай сурвалжлах хэсгийг Дурангийн оношлогооны төвийн үүдэнд ирэхэд үйлчлүүлэгчдийн дараалал үүсч, “Д.Даваадорж профессорт үзүүлэх гэсэн юм” хэмээх иргэдийн эрт ирсэн нэгэн нь үзлэгийн өрөөний гаднах сандал дээр сууж, зарим нь үзлэгийн өрөөний хаалга бараадан зогсож байлаа. Д.Даваадорж профессор ирснээр түүнд үзүүлэх гэсэн иргэд эхнээсээ тасагт орж эхлэв. Дурангийн оношлогооны төвийг Япон улсын OLYMPUS фирмийн тусламжтайгаар байгуулсан гэнэ. Тиймээс тус төвд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжүүдэд эерэгтэй өндөр хүчин чадалтай аж. Оношлогооны төвийн дотор талд ариун цэврийн байдлыг өндөр зэрэгт сахисан байх бөгөөд хэрэглэгдэх жижиг

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

багаж, хэрэгслийг нямбайлан эмх, цэгцтэй тавьсан харагддаг. Эхний үйлчлүүлэгч орж ирмэгц дурандуулахын өмнөх бэлтгэл ажлыг хангалаа. Ингээд дурандах үйл ажиллагаа эхлэхэд Д.Даваадорж профессор дадлагажигч эмч нартаа мэдэхгүй, чадахгүй зүйлсийг тайлбарлаж өгнө. Түүнийг тойрон эмч, сувиллагч, дадлагажигч эмч нар зосгох бөгөөд тэдний урд өнгөт дэлгэцэн дээр дурангийн үйл ажиллагаа тод харагдана. Энэ үеэр резидент эмч нар өөрийн мэдэхгүй чадахгүй зүйлийг түүнээс асууж авдаг байна. Ингэж л их сургуулийн эмнэлгийн сургалт явагддаг ажээ. Тэгэхдээ тухайн үзүүлж буй хүнд ямар нэгэн төвөг огтхон ч учруулаагүй гэдгийг онцолмоор байна. Үйлчлүүлэгч зөвхөн эмчдээ үзүүлдэг л гарч байсан. Ийнхүү Д.Даваадорж

зэрэг бүх төрлийн дурангийн мэс засал хийдэг аж. Энэ үеэр профессор Пак Кван Тэ манай эмнэлгийн дурангийн мэс засал өндөр хөгжсөн гэдгийг онцолсон. Мөн тус эмнэлэгт судасны мэс засал ч их хийгддэг байна. Сүүлийн үед монголчуудын дунд бөөрний архаг дутагдал ихэссэн. Үүнтэй холбогдуулан диализын эмчилгээнд орохын өмнөх судасны хагалгааг сургалтын нэгдсэн эмнэлэгт хийлгэхээр зорьж ирэх хүмүүсийн тоо олширчээ. Жилд гэхэд 500 орчим хагалгаа хийдэг байна. Түүнээс их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлгийн онцлогийн талаар сонирхон асуухад “Дэлхийн хэмжээнд хамгийн өндөр төвшний эмнэлэг нь анагаахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургуулиудын сургалтын эмнэлгүүд байдаг. Солонгост



# АШУУИС-ИЙН СУРГАЛТЫН ЭМНЭЛЭГ



профессорыг тойрон зогсох дадлагажигч эмчийн нэг нь Цэвэлмаа юм. Тэрбээр 2014 онд АШУУИС-ийг хүний их эмч мэргэжлээр тэгсч, 2014 онд хүүхдийн эмчээр мэргэшиж, 2016 онд хүүхдийн гастроэнтерологийн эмчээр резидент хийжээ. Харин эдүгээ хүүхдийн хоодоод гэдэсний дурангийн эмчээр мэргэжил дээшлүүлж байгаа юм байна. Энэ тухайгаа ярихдаа “Би сургуулиараа бахархдаг. Сургуулиараа бахархахад нөлөөлдөг нэг зүйл нь гэвэл сургалтын нэгдсэн эмнэлэг юм. Бид эндээс маш их мэдлэгийг олж авдаг. Хичээл нь ч үр дүнтэй байдаг. Жишээлбэл, дурангийн хичээл гэхэд дурангийн үйл ажиллагаа явагдаж байхад багш нар маань одоо энийн нь дурандаж байна. Ийм эмгэгтэй, өөрчлөлттэй байна. Энэ нь эрүүл байна гээд бүгдийг нь дэлгэрэнгүй хэлж өгдөг. Мөн бид суралцаж байх хугацаандаа гахайн хоодоонд дурангийн туршилтаа хийдэг. Багш нар маань эмч багш гэдэг утгаараа маш ойлгомжтой заадаг. Тэр нь бидэнд суралцахад их амар байдаг. Сургалтын бааз ч гэсэн бэлэн байдаг. Дурангаа угаахаас эхлээд л бүх зүйлд эхнээс нь суралцдаг” гэсэн юм.



Мэс заслын тасгийн эмч нар жилд 500 орчим хагалгаа хийдэг

Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэгт харж болох нийтлэг зүйл нь гадаадын доктор профессорууд. Тэр дундаа БНСУ-ын туршлагатай, мэргэшсэн эмч нар ажилладаг тасаг. Бидний орсон дараагийн тасаг бол Мэс заслын тасаг. Энд бид Мэс заслын тасгийн эмч, АШУУИС –ийн багш, АУ-ны доктор, профессор Пак Кван Тэ эмчтэй уулзаж, тус тасгийн үйл ажиллагаатай танилцсан. Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасаг нь ерөнхий мэс засал, чих хамар хоолой, нүд, эрүү нүүр, гэмтлийн чиглэлээр мэс заслын тусламж үйлчилгээг хүргэдэг гэнэ. Тэр дундаа цөс, олгой, эвэрхий, нойр булчирхай, дэлүү

ч мөн адил. Монголчууд их сургуулийн эмнэлгийн талаар буруу ойлголттой байдаг. Их сургуулийн сургалтын эмнэлэг гэхээр оюутан, резидент эмч нар хагалгаа хийдэг, хүн үздэг гэж ойлгодог. Тийм биш юм. Их сургуулийн нэгдсэн эмнэлэгт хамгийн өндөр зэрэгтэй доктор, профессорууд ажилладаг. Тэр хүмүүс нь хагалгаа хийж, өвчтнүүдээ үздэг. Оюутан, резидент эмч нар хийдэггүй. Харин тэр мундаг доктор,

профессоруудын эмчилгээний үйл явцаар оюутан, резидент эмч нарыг сургана гэсэн үг. Монголд анагаах ухаан сайн хөгжөөгүй хамгийн гол учир нь гэвэл сургалтын эмнэлэг байдаггүйтэй холбоотой. Гадаадын эмч, мэргэжилтнүүд ингэж үздэг. Яах вэ, улсын эмнэлэг дээр сургалт бий. Гэхдээ хангалттай биш. Тиймээс Монголд их сургуулийн нэгдсэн эмнэлгийг цаашид олноор байгуулах

хэрэгтэй. Анхных нь эмнэлэг АШУУИС-ийн дэргэд байгуулагдаад бид эмнэлэгтэй ажиллахын хажуугаар багшилж байна. Анагаахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургуулиуд хажуудаас сургалтын эмнэлэгтэй байж сая анагаах ухаан зөв төвшнөөрөө хөгждөг” гэв. Үнэхээр ч түүний хэлдэг зөв. Манай улсын иргэд сүүлийн үед гадаад руу эмчилгээнд явах болсон. Энэ тухайгаа хамгийн сайн үйлчилгээг авахын тулд гэж тайлбарлах нь бий. Гэхдээ зорьж очсон хамгийн сайн эмнэлэг нь их сургуулийн сургалтын эмнэлэг байх нь элбэг. Арга ч үгүй юм. Их сургуулийн нэгдсэн эмнэлгүүдэд тухайн улсын хамгийн сайн гэсэн доктор, профессорууд ажилладаг юм чинь. Тэгвэл манай улсад ч гэсэн шилдэг доктор, профессоруудыг цуглуулсан эмнэлэг аль хэдийнэ бий болжээ. Биднийг түүнтэй

...“Манай улсын зарим иргэд зөвхөн онош нь тодроогүй гэх шалтгаанаар гадаадын олон улсыг зорьсоор байна. Үүнээс болж иргэдэд санхүү эдийн засгаас эхлээд их хэмжээний хүндрэл учирдаг. Тиймээс бид нэн тэргүүнд бүхнийг оношилдог болохыг зорилгоо болгосон...”

Монгол, Солонгосын доктор, профессоруудаар багаа бүрдүүлжээ

Бид сурвалжлагаа бэлтгэж явцдаг тус эмнэлэгт ажиллаж буй гадаадын доктор, профессорууд багт Монголчуудын дунд “Хүүхдийн Чой” гэх нэрээр танил болсон БНСУ-ын Ионсей Эрүүл Мэндийн байгууллагын Монгол дахь төлөөлөгч Чой Вон Гю эмч ажиллаж байгааг авч уулзлаа. Тус тасаг нийт 20 ортой бөгөөд дотрын 14, мэс заслын зургаан ор байдаг гэнэ. Хэвтэх тасаг нам гүм цаанаа л нэг тухтай харагдаж байв. Өрөө бүрт 2-4 ор байрлуулжээ. Бид тус эмнэлэгт хэвтээд хоёр хонож буй Б.Уржинтэй ярилцсан. Тэрбээр “Энэ эмнэлгийн үйлчилгээ маш сайн. Хэвтээд удалгүй эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээ мэдэгддэг шүү дээ. Би цус багадалттай, элэг бага зэргийн өөрчлөлттэй гэдэг оноштойгоор хэвтсэн. их сургуулийн эмнэлгийн хамт олонд баярлалаа гэж хэлмээр байна” гэв.

Гю эмчид тасралтгүй үзүүлж байсан юм. Манай сурвалжлах хэсэг түүнийг түр амсхийх үеэр нь цөөн хором ярилцсан. “АШУУИС-ийн сургалтын нэгдсэн эмнэлэг бол Монголын эрүүл мэндийн салбарын ирээдүй юм. Яагаад гэвэл резидент эмч болон оюутнуудаа өөрийн бааз эмнэлгээр дамжуулан бэлтгэдэг. Дэлхийн өндөр хөгжилтэй орны эрүүл мэндийн салбар ч энэ чиглэлээр явдаг. Өндөр хөгжилтэй орны сургууль бүр сургалтын эмнэлэгтэй байдаг. Тиймээс бид боловсрол, сургалт, эмнэлзүй, судалгааг бүх тасагтайгаа уялдуулан хөгжүүлэхийг эрхэмлэж байна. Мөн сайн багш, сайн эмч нар ажиллаж байгаа учраас тэр сайн эмнэлэг гэж ойлговол өрөөсгөл. Сүүлийн үед дэлхий нийтээр багаар ажиллаж байна. Зөвхөн эмчийг бэлтгэх бус, туслах ажилчдыг ч бэлтгэх болсон. Тухайлбал, Сувиллагч зөвхөн эмчийн туслагч биш мэргэжилтэн шүү дээ. Тэгэхээр салбар бүрт сайн мэргэшсэн сувиллагчийг бэлтгэж байна. Мөн мэргэшсэн техникчийг бэлтгэж байгаа” гэв. Түүнчлэн сүүлийн үед дэлхий нийтээр эрхэмлэж буй чанартай үйлчилгээг ч тус эмнэлэг эрхэмлэж, чанарын алба байгуулан ажиллаж байгаа аж. Чой Вон Гю эмч маань өмнө нь Монголын ард түмний сайн мэдэх “Ионсей Найрамдал Эмнэлэг”-ийн даргаар ажиллаж байсан юм. Тэрбээр тэр үед Ионсей Найрамдал эмнэлгээр үйлчлүүлж байсан үйлчлүүлэгчдийнхээ өвчтөнийг картуудыг энэ эмнэлэгт авчраад байгаа бөгөөд энэ нь Ионсей найрамдал эмнэлгийн картаараа уг Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэгт үргэлжлүүлэн үзүүлэх боломжтой гэсэн үг. Ийм буянтай үйл хийж байгаа Чой эмчтэй ярилцахад баярлах, бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрж байсан юм. Манай сурвалжлах хэсэг Чой Вон Гю эмчтэй ийн ярилцсаны дараа Хэвтэн эмчлүүлэгчдийн тасагт очсон. Биднийг очих үед тасгийн эмч уушиг судлалын профессорын багийн багш, доктор Ч.Маналжав хүлээн авч уулзлаа. Тус тасаг нийт 20 ортой бөгөөд дотрын 14, мэс заслын зургаан ор байдаг гэнэ. Хэвтэх тасаг нам гүм цаанаа л нэг тухтай харагдаж байв. Өрөө бүрт 2-4 ор байрлуулжээ. Бид тус эмнэлэгт хэвтээд хоёр хонож буй Б.Уржинтэй ярилцсан. Тэрбээр “Энэ эмнэлгийн үйлчилгээ маш сайн. Хэвтээд удалгүй эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээ мэдэгддэг шүү дээ. Би цус багадалттай, элэг бага зэргийн өөрчлөлттэй гэдэг оноштойгоор хэвтсэн. их сургуулийн эмнэлгийн хамт олонд баярлалаа гэж хэлмээр байна” гэв.

“Нэн тэргүүнд бүхнийг оношилно”

Монгол Улсын эрүүл мэндийн

салбартих сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэг хэмээх орон зайг бий болгохоор зорьж яваа хамт олонд хийсэн ажил, хэлэх үг олон ажээ. Уулзсан хүн бүр хийсэн ажил, цаашид хэрэгжүүлэхээр зорьж буй ажлуудаа танилцуулж байсан. Тэр болгоныг энд дурдах илүүц биз. Харин манай сурвалжлах хэсэг 2018 оны долдугаар сард ашиглалтад орох энэ эмнэлгийн бэлтгэл ажлыг зохион байгуулж буй Стратеги төлөвлөлтийн албаны дарга Н.Эрдэнэхүүтэй уулзсан юм. Түүний хэлснээр шинэ эмнэлгийн барилгын ажил төлөвлөсөн хугацаанаасаа нэг сараар түрүүлж яваа аж. Үүнтэй зэрэгцээд боловсон хүчнээ бэлтгэх, зорилго, зорилгоо болон тэргүүлэх чиглэлээ тодорхойлохоос эхлээд олон ажил явагдаж байгаа талаар бидэнд хуучилсан юм. Тус албаны өрөөний зүүн ханан дээр тун гэгч самбар өлгөжээ. Энд их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлгийн шинэ барилгатай холбоотой бүх төлөвлөгөөг өнгөөр ялган бичиж, өнгөөр хэвлэн гаргасан байлаа. АШУУИС-ийн сургалтын нэгдсэн эмнэлэг “Нэн түүнд бүхнийг оношилно” гэх зорилгыг тавьжээ. Энэ талаар Н.Эрдэнэхүү дарга “Манай улсын зарим иргэд зөвхөн онош нь тодроогүй гэх шалтгаанаар гадаадын олон улсыг зорьсоор байна. Үүнээс болж иргэдэд санхүү эдийн засгаас эхлээд их хэмжээний хүндрэл учирдаг. Тиймээс бид нэн тэргүүнд бүхнийг оношилдог болохыг зорилгоо болгосон. Зорилгодоо хүрэхийн тулд тоног төрөөрмж, боловсон хүчнээ бэлтгэж байна. Түүнээс гадна тэргүүлэх чиглэлээ тодорхойлж хөгжүүлнэ. Бид элэг, бөөр шилжүүлэн суулгах мэс засал болон манай улсад хийдэггүй нүд, чих хамар хоолойн нарийн мэс заслыг тэргүүлэх чиглэлээ болгон ажиллах юм. Мөн бусад төрлийн бичил болон төрөлжсөн мэс заслыг хөгжүүлнэ” гэв.

АШУУИС-ийн хэмээх тодотголтой сургалтын нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцахад ийм байлаа. Улсдаа профессорын багш, хүндтэй доктор, профессорууд чанартай үйлчилгээг иргэдэд хүргэхийн зэрэгцээ оюутнууд болон резидент эмч нар тус сургалт явуулсаар байна. Чадвартай эмч нараар багаа бүрдүүлсэн болоод ч тэр үү тус эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээнд үйлчлүүлэгчид нь тун сэтгэл ханамжтай байх юм билээ. Ямартай ч АШУУИС-ийн сургалтын нэгдсэн эмнэлгийнхэн шинэхэн байрныхаа бэлтгэл ажлаас эхлээд эмнэлгийнхээ зорилго, төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө ажиллаж байсан юм. Монголын анагаахын салбарын ирээдүйг чиглүүлэгчид олон улсын жишигт нийцсэн шинэ менежмент, шинэ техник, технологитой ажиллахад боловсон хүчин болоод ур чадварын хувьд аль хэдийнэ дадлагдажсан нь сурвалжлага хийх явцад анзаарагдаж байлаа.

# STRESS

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Залуусыг хөгжүүлэх мэдээллийн төв иээгдлээ

Н.БАТЗАЯА

“Залуус”-ын гэх тодотголтой манай улсын нийслэлд үнэндээ залуучууд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх газар тун хомс. Нэрлэх гээд үзвэл кино театр, фитнес... гээд л тоотойхон. Гэхдээ эдгээр зүйлсийг хийхэд тодорхой хэмжээний мөнгө шаардлагатай. Санхүүгийн хэрэгцээнээс шалтгаалаад оюутан, залуус тэр бүр чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, өөрийгөө хөгжүүлэх тал дээр хойрго хандах нь бий. Тэгвэл залуусын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, тэдний оюуны хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой Солонгосын мэдээллийн төв нээгдлээ. Уг төвийн нээлт өчигдөр Монголын Залуучуудын холбооны байранд болсон юм. Тус төвийн нээлтэд БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайд У Сун, МЗХ-ны Ерөнхийлөгч А.Мөнхбат болон бусад албаны хүмүүс оролцлоо. Тус төвийг нээж, БНСУ-ын Элчин Сайд У Сун “Биднийг анх энэ төвд ирэхэд ийм байгаагүй. Өөр байдалтай байсан. Өнөөдөр ийм сайхан болсонд баяртай байна.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



Солонгосын мэдээллийн төв нь Монголын залуучууд болон маш олон оюутан сурагчдад хүрч үйлчлэх зорилготойгоор байгуулагдсан. Цаашид солонгосын мэдээллийн төвийг илүү олон хүн мэдэх байх гэж бодож байна. Мөн бид мэдээллийн төвд илүү олон сонин, сэтгүүл номыг байрлуулах болно. Өнөөдрөөс эхлээд энэ төв Солонгосын элчин сайдын яамны биш МЗХ-ны харьяа төв болж байгаа юм. Мэдээллийн төвийн үйл ажиллагааг цаашид сайн авч явахыг хүсэн ерөөе” гэв. Залуучууд чөлөөт цагаа

үр дүнтэй өнгөрөөх, сурч боловсрох таатай орчин нөхцөлөөр хангах зорилготой тус төв нь Монголын Залуучуудын Холбооны төв байрны II дугаар давхарт байрлах бөгөөд номын сан

нь оюутан, залуучуудад тодорхой цагийн хуваарийн дагуу нээлттэй үйлчлэх аж. Мөн номын сан нь үнэгүй интернэтэд холбогдсон суурин компьютерууд, iPad цахим ном уншигч, уншлагын болон

лекцийн танхимууд, Wi-fi орчинтой уншлагын өрөөнүүдтэй бөгөөд Солонгос хэл дээрх уран зохиолын болон бусад салбар шинжлэх ухааны ном, сэтгүүл байрлуулжээ. Түүнчлэн Солонгосын соёлын өдөрлөг зохион байгуулж, Солонгос улсад суралцах боломжуудын талаар цуврал зөвлөгөө өгөх гэнэ. Уг номын санд КОЙКА Олон улсын байгууллагаас сайн дурын ажилтан ажиллуулахаар МЗХ-оос хүсэлт тавьсаны дагуу 2017 онд Солонгосын мэргэжлийн номын санч олон улсын стандартын дагуу оюутан, залуучуудад үйлчлэх юм байна. Энэ үеэр МЗХ-ны Ерөнхийлөгч А.Мөнхбат “Монголын нийт залуучуудын нэрийн өмнөөс болон хувнасаа энэхүү төвийг байгуулж өгөхөд дэмжлэг үзүүлж буй БНСУ-ын ЭСЯ болон эрхэм Элчин Сайд У Сун танд баярлаж талархсанаа илэрхийлмээр байна. Энэхүү төвийг байгуулснаар Монгол оюутан, залуучууд тав тухтай, таатай орчинд номын сангаар

нээлттэй үйлчлүүлж, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөж, Солонгос Улсын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч, цаашид сурч боловсрох илүү боломжуудыг олж авна гэдэгт итгэлтэй байна. Солонгосын талтай бид найрсаг харилцаа, нягт хамтын ажиллагаатай байдаг. Тухайлбал 2013 онд МЗХ-ны төлөөлөл Сөүл хотноо айлчлан, Солонгосын Залуучуудын Холбоотой холбоо тогтоож, санамж бичигт гарын үсэг зурсан бол 2014, 2015 онуудад тус байгууллагын тэргүүн манай Холбоонд удаа дараа айлчлан ирсэн нь өнөөдрийн хамтын ажиллагааны эхлэлийг тавьлаа. Мөн 2016 онд хоёр орны залуучуудын судлалын хүрээнд Солонгосын судалгааны хүрээлэнгтэй хамтран ажиллах санал солилцсон” гэсэн юм. Нээлтийн ажиллагааны үеэр БНСУ-ын ЭСЯ болон МЗХ солонгосын мэдээллийн төв байгуулж буйтай холбоотой, цаашдын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор санамж бичиг байгуулсан.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -8  
Шөнө -19

Нөгөөдөр  
Өдөр -6  
Шөнө -16

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН ЛУУ ӨДӨР

Аргын тооллын: 2016.11.30,  
Лхагва гараг  
Наран ургах шингэх: 08.20-17.02  
Үс засуулбал: Нас ахар болно



Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, торь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвэ ололцох, халтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурит хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг нотломтох, хөгжлийн злтсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар ухаар одогсод зүүн зүгт төрөө гаргавал зохистой. Балжиннялтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДУУЛГАХ СОНИН


### Мэрайя Кэрри, Ник Кэннон НАРЫН ГЭР БҮЛ ЭРГЭН НЭГДЛЭЭ

Дуучин Мэрайя Кэрри түүний салсан нөхөр хөтлөгч Ник Кэннон нар Талархлын баярыг хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлжээ. АНУ-джил бүрийн арваннэгдүгээр сарын 24-ний өдрийг “Талархлын баяр” болгон тэмдэглэдэг бөгөөд америкчууд энэ өдрийг гэр бүл найз нөхдөрөө цугларч цадталаа идэж, хөгжилдөн өнгөрүүлдэг уламжлалтай. Тэгвэл уг баяраар Ник Кэнноны гэр бүл эргэн нэгдэж

Хавай арлын Хонолулууд хүүхдүүдтэйгээ Талархлын баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Тэд мөн зургаа инстаграмм хуудаастаа нийтэлж, шүтэн бишрэгчиддээ сонирхуулжээ. Мэрайя Кэрри Ник Кэннон нар 2014 онд салсан байдаг. Гэсэн хэдий ч, жил бүрийн Талархлын баяраар гэр бүлээрээ эргэн нэгддэг байна. Өнгөрсөн жил ч гэсэн эл баярыг хүүхдүүдтэйгээ хамтдаа өнгөрүүлжээ.

### “Атганд үлдсэн эрдэнэ” киног ОСКАРТ НЭР ДЭВШҮҮЛЖЭЭ

Продюсер, зураглаач Д.Ангараг АНУ-ын Кино академийн дээд шагнал Оскарын Гадаад хэл дээрх кино төрөлд Монгол Улсаас нэг киног нэр дэвшүүлэх бүрэн эрхт Академийн гишүүн болсон. Тэрбээр 2017 оны 89 дэх Академийн шагнал Оскарын гадаад хэл дээрх кино номинацид “Хувьсал” продакшны бүтээл “Атганд үлдсэн эрдэнэ” уран сайхны киног нэр дэвшүүлжээ. Одоогоор шилдэг гуравт үлдэх эсэхийг хэлэх боломжгүй байгаа аж. Сонирхуулахад зураглаач Д.Ангараг тус киноны ерөнхий зураглаачаар ажилласан юм.



Бидэнд тохиолдсон

**Хүндхэн хөгтэй явдлууд**

**Ган Чинмэг**

Хадмындаа анх очоод пакталсан тухай шүү. Гэрийнх нь утас дугаараад хадам ээж юм угаагаад завгүй намайг авчих гэсэн юм. Утас авсан чинь хадам аавтай ярьж гэж байна. Амьдралдаа ааваасаа өөр хүнийг аава гэж үзээгүй байлаа. Хаха. Ааваа тантай утсаар ярьж гэж байна гэх хэцүү. Ахаа гэх ч хэцүү. Тэгээд би утсаа шууд тасалчихсан. Тэгсэн утас дахиад залгаж байна. Хадам ээж “Хэнтэй ярьж гэж байна” гээд л хүрээд ирлээ. Би бодж бодож “Таны нөхөртэй...” хаха.

**ТЭНГИС** ТӨСӨӨЛӨӨС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...

### ХЯМДРАЛ, УРАМШУУЛАЛ

Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
ЭХНИЙ ҮЗВЭР БҮР ХЯДАРАЛТАЙ: Төм хүн - 5000Т, Хүүхэл - 4000Т						
Хосуудын өдөр	Оюутаны өдөр	Ахмалын өдөр				
Хосоороо ирсэн хүн бүрт тасалбар	Өдрийн дурш оюутануудад тасалбар	10:00-17:00 Цагийн хооронд тасалбар				
5000Т	5000Т	4000Т				

### ТӨРСӨН ӨДРИЙН УРАМШУУЛАЛ

Тасалбаргаа авааг → Ундаа, Пасторчи → Уусуури

### ЭЛСЭЛТИЙН ЗАР

“Зохномж” дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн омнох боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

**Жич:**  
-IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийн нэмэлт цагаар нөхүүлнэ  
-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.  
Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021